



БАТЛАВ  
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш. БАЯНМОНХ

*Миржигийн*



БАТЛАВ  
ТОРГО МАГНАГ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ ХХК. ЭНХЖИН

*Т.Энхжин*

## ДХХА СЭЛБЭГ ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар № 15/2022

2022 оны 03-р сарын 14 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх нөгөө талаас Торго магнаг ХХК-ийг төлөөлж захирал Т.Энхжин /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дах заалт, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ”гэх) байгуулав.

### Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1. Нийлүүлэгч нь ”ДХХА сэлбэг хэрэгсэл” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтанд заасан барааг нэр төрөл, тоо хэмжээ, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

### Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1. Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш 30 /гуч/ хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

### Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

3.1. Энэ гэрээний нийт үнэ 81,717,500 /наян нэгэн сая долоон зуун арван долоон мянга таван зуу/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль Онцгой албан татвар, Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх тээврийн зардал НӨАТ бүгд шингэсэн байна.

3.2. Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.

3.3. Барааг хүлээлгэн өгсөний дараа бараа хүлээн авсан баримт, гэрээ дүгнэсэн акт баталгаажсанаас хойш 90 ер/ хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Голомт банкны 4605116905 тоот дансанд шилжүүлнэ.

### Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

4.1. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

4.2. Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн

дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.

- 4.3. Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсэний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4. Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн ДХХА инженер Ч. Нямцэрэн хариуцан ажиллана. Утас- 99024380.
- 4.5. Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Торго магнаг ХХК-ийн захирал Т.Энхжин хариуцан ажиллана. Утас- 88899460.

#### **Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол**

- 5.1. Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2. Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед норох, гоожихоос хамгаалсан сав, баглаа боодолтой байна.
- 5.3. Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4. Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5. Нийлүүлэгч нь нийлүүлсэн барааг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш **12** сарын баталгаа гаргана. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл, доголдлыг өөрийн зардлаар засаж залруулах үүрэгтэй.
- 5.6. Барааг дараах бичиг баримт дагалдана.
- Уйлдвэрлэгчийн сертификат

#### **Зургаа. Бараа хүлээн авах**

- 6.1. Нийлүүлэгч нь ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2. Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

#### **Долоо. Давагдашгүй хүчин зүйл**

- 7.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2. Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 10 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөне.

#### **Найм. Гэрээг цуцлах үндэслэл**

- 8.1. Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид захиалагч гэрээг цуцлах ба баталгааг буцаан олгохгүй.
- 8.2. Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс

бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

### Ес. Бусад нөхцөл

- 9.1. Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 10 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнэ.
- 9.2. Талууд аль нэгийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4. Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5. Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 9.6. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7. Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.


#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧИЙН АЖИЛ ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Ө. УДВАЛ  
Гарын үсэг: 

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Г. ЭРДЭНЭБИЛЭГ  
Гарын үсэг: 

НЭГДСЭН ЦЕХИЙН ДАРГА  
Ж. АРИУНЖАРГАД  
Гарын үсэг: 

ДХХА ИНЖЕНЕР  
Ч. НЯМЦЭРЭН  
Гарын үсэг: 

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Г. САРУУЛ  
Гарын үсэг: 

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:  
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Ш. ГАНТУЛГА  
Гарын үсэг: 

Хаяг: Монгол улс, Улаанбаатар  
хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1  
Утасны дугаар: 77111251  
РД: 6021646

#### НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ТОРГО МАГНАГ  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ  
Т. ЭНХЖИН ATA3781 4557298  
Гарын үсэг:



Хаяг: Баганур дүүрэг 3-р хороо 41-10  
Утас: 88224720  
РД: 4557298

25/2022 Тоот гэрээний хавсралт

ДХХА сэлбэг хэрэгсэл нийлүүлэх барааны жагсаалт

№	Бараа материалын нэрс	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Утааны хийн найрлагын хэмжүүрийн серверийн компьютер	Dell percision t5600	ш	1	7,500,000	7,500,000
2	Галын хотол болон циклоны температурын датчик	K төрлийн 0-1300 °C хэмжих хязгаартай, Ф25 мм, 850/950 мм-ийн урттай, элсний үрэлтэнд тэсвэртэй, Ажлын биесийн температур 950°C	ш	25	520,000	13,000,000
3	Зуухны шатаах камерын температурын датчик	K төрлийн 0-1300 °C хэмжих хязгаартай, WRN-130NM	ш	1	520,000	520,000
4	Зуухны асаагуурын температурын датчик	K төрлийн 0-1200 °C хэмжих хязгаартай, WRNR2-42NT	ш	1	520,000	520,000
5	Асаагуурын өндөр хүчдэлийн гал асаах төхөөрөмж	High-power ignition equipment Model: JGP-20, input: 220V, LxWxH: 300x240x125, spark frequency:15Hz, weight:10kg	ш	1	2,200,000	2,200,000
6	Цахилгаан хөдөлгүүрүүдийн доргионы мэдрэгч	DK300/VS-020 45mV/mm/s	ш	10	1,900,000	19,000,000
7	Зуухны хүчилтөрөгчийн хэмжүүрийн циркон мэдрэгч	ZIRCONIA CELL	ш	2	2,800,000	5,600,000
8	Зуухны нүүрс тэжээгчийн жингийн хэмжүүрүүдийн санах ойн удирдлагын плат	SAIMO XR6000 CPU BOARD	ш	1	2,000,000	2,000,000
9	Зуухны нүүрс тэжээгчийн жингийн хэмжүүрүүдийн алсын удирдлагын болон сигналын плат	Saimo 6105-S5 Relay output board V13-10-10	ш	2	2,000,000	4,000,000
10	Нүүрс тэжээгчийн жингийн хэмжүүрийн хурд мэдрэгч	PLR2300, 10-30Vdc	ш	2	700,000	1,400,000

11	Конвейрын жингийн хэмжүүрийн хурд мэдрэгч	Model: PLR2050, Serial №06040, 12Vdc, Res:32 Ohm, Current:0.38A/ph	ш	1	800,000	800,000
12	Нүүрс тэжээгчийн хийн соронзон реле	Model: 4V230E-08	ш	2	180,000	360,000
13	Зуухны нүүрс тэжээгчийн санах ойн удирдлагын платны батерий	CR1220 lithium battery 3V	ш	15	4,500	67,500
14	Нүүрсний бункерын түвшний хэмжүүрийн контроллёр	princo 4641	ш	1	9,000,000	9,000,000
15	Нүүрсний бункерын түвшний датчик	Sonocell transducer SC-14PT	ш	1	1,450,000	1,450,000
16	Температур тохируулагч	Model: CH402FK02-M*AN, 0-400°C	ш	1	150,000	150,000
17	Шаарганы бункерын хийн соронзон хаалтны удирдлагын контроллёр	DMK-4CS-6	ш	1	420,000	420,000
18	Шаарганы бункерын хийн хаалтны соронзон реле	Model: 4V330C-10	ш	1	180,000	180,000
19	Нарийн үнсний аспирацийн хийн хаалтны удирдлагын контроллёр	LC-PDC-ZC12A	ш	1	280,000	280,000
20	Нарийн үнсний аспирацийн хийн соронзон хаалт	Best- Nr.0200 AC220V	ш	4	140,000	560,000
21	Компрессорын соронзон реле	Solenoid valve MVSC-220-4E1	ш	2	180,000	360,000
22	Уутат шүүлтүүрийн оройн уут сэгсрэх соронзон реле	Magnet-Schultz X BK K 032 K54 F01, 24Vdc, 0.486A, s0.8mm	ш	4	180,000	720,000
23	Уутат шүүлтүүрийн шууд болон тойруугийн хаалтнуудын соронзон реле	(SR561B-RN38DW)	ш	3	130,000	390,000
24	Уутат шүүлтүүрийн шууд болон тойруугийн хаалтнуудын концевк	LXK-3-20S/T	ш	3	90,000	270,000
25	Уутат шүүлтүүрийн Ø50, 80, 200-ын хийн хаалтнуудын соронзон реле	(YA2BA4522G00040)	ш	2	450,000	900,000

26	Сүлжээний усны гадна байрласан хамгаалалтын даралтын датчикны самбарын халаагч тенийн контактор	CHINT CJX2-09, 25A	ш	1	50,000	50,000
27	Сүлжээний усны гадна байрласан хамгаалалтын дифференциаль даралтын датчикны самбарын халаагч тенийн контактор	CHINT NC1-09, 25A	ш	1	50,000	50,000
28	Авто угсрааны метал мэдрэгч	U-GAGE Proximity switch: T30UXDA, 10-30 V dc	ш	2	950,000	1,900,000
29	Вагон хөмрөгчийн замын мэдрэгч	XSDA400519	ш	2	750,000	1,500,000
30	Вагон хөмрөгчийн гидрийн мэдрэгч	HED 8 OP-20/50K14S	ш	1	2,500,000	2,500,000
31	Вагон хөмрөгчийн фото мэдрэгч	Фото мэдрэгч: RLK28-55/31/116, 12-240 AC/DC	ш	2	1,070,000	2,140,000
32	Дотоод хэрэгцээний даралтын датчик	HCY-SS16Bar, range:0-6bar, 24Vdc, output: 4-20mA	ш	2	420,000	840,000
33	Манометрийн сифон хоолой	Нерж сифон хоолой	ш	10	28,000	280,000
34	Буцах усны хамгаалалтын даралтын датчикны холбох хайрцагны халаагч тень	Халаалтын хуурай тень 1kВт, 5A, 220V	ш	1	110,000	110,000
35	ЭКМ	0-2,5MPa	ш	2	85,000	170,000
36	Уутат шүүлтүүрийн клемний хайрцаг, клем	Оролт, гаралтын 8 кабелийн үзүүр холбогдох клемний жижиг хайрцаг	ш	20	22,000	440,000
37	Цахилгаан хаалтны тосолгоо үйлчилгээ хийх товуд авах	ZL-2 дисульфид	кг	2	45,000	90,000
<b>Нийт Дүн /НӨАТ багтсан болно/</b>						<b>81,717,500.0</b>

Амгалан дулааны станц ТӨХК-ийн

Нэгдсэн цехийн дарга

Ж. Ариунжаргал  
Гарын үсэг: 

Торго магнаг ХХК-ийн

Захирал

Т. Энхжин  
Гарын үсэг: 